

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/173/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ө.Ринчинмядаг
Утас: 70323108 Цахим хаяг:
rinchinmyadagu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

ТӨР ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.17 № 180
танай _____-ны № _____-т

АРВАЙХЭЭР СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ээлжийн амралтын цалин олгохдоо 13 албан хаагчдад нийт 656.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон, байгууллагын ажилчдад 1380.0 мянган төгрөгөөр хувцас, 4,009.6 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дүгээр заалт, УСНББОУС 24-Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга стандартад нийцэхгүй, Үнэлгээ ба хуваарилалт, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\Auditin gaza\baiguullagiin dotood barimt\A4

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34099066.00</u>	<u>31697344.50</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	34099066.00	31697344.50
351	Түүхий эд материал	260000.00	260000.00
35130	Эм боох материал	260000.00	260000.00
354	Хангамжийн материал	33839066.00	31437344.50
35410	Бичиг хэргийн материал	324000.00	300000.00
35420	Аж ахуйн материал	23663310.00	19945400.00
35450	Барилгын засварын материал	722000.00	722000.00
35460	Хүнсний материал	3744900.00	3320088.50
35470	Бусад хангамжийн материал	5384856.00	7149856.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>335817334.93</u>	<u>337138710.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	335817334.93	337138710.90
392	Биет хөрөнгө	286755251.63	288241627.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	271883562.82	283512113.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24158537.52	-35595941.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47484252.00	40139652.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18639966.56	-17705805.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19802005.67	24984918.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11970081.78	-15050979.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	3000000.00	7000000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3000000.00	0.00
39217	Ном	2354017.00	957670.50
393	Биет бус хөрөнгө	49062083.30	48897083.30
39301	Программ хангамж	1315000.00	825000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-952916.70	-627916.70
39303	Бусад биет бус хөрөнгө	48700000.00	48700000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>369916400.93</u>	<u>368836055.40</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>369916400.93</u>	<u>368836055.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	369916400.93	368836055.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	197382080.00	197382080.00
51101	Өмч: - төрийн	197382080.00	197382080.00
512	Хуримтлагдсан үр дүн	20703242.33	19622896.80
51210	Өмнөх үеийн үр дүн	20703242.33	20703242.33
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-1080345.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	151831078.60	151831078.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>369916400.93</u>	<u>368836055.40</u>

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416537552.00	404547678.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10134052.00	6605240.00
120	Нийтлэг татварын бус орлого	10134052.00	6605240.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10134052.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10134052.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		3175940.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		3429300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406403500.00	397942438.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	374260400.00	342905900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	374260400.00	342905900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175000.00	22625238.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22485238.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175000.00	140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31968100.00	32411300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31968100.00	32411300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	438948848.76	402914205.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438948848.76	402914205.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427775024.37	399660260.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293903829.00	279844416.79
210101	Үндсэн цалин	193880824.00	188146639.79
210102	Нэмэгдэл	77838454.00	71426477.00
210104	Урамшуулал	22184551.00	20271300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37144097.13	36729685.85
210201	Тэтгэврийн даатгал	25191297.13	25469418.37
210202	Тэтгэмжийн даатгал	2988200.00	2830816.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2390600.00	2247853.40
210204	Ажилгүйдлийн даатгал	597600.00	561963.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5976400.00	5619633.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26320633.48	27824953.00
210301	Гэрэл, цахилгаан	2485756.48	1595130.00
210302	Түлш, халаалт	21322500.00	23377200.00
210303	Цэвэр, бохир ус	2512377.00	2852623.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19868972.00	12086298.00
210401	Бичиг хэрэг	2237500.00	991900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	709800.00	757800.00
210404	Ном, хэвлэл		184500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	455900.00	380538.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16465772.00	1885650.00
210408	Бараа материал акталсны зардал		7885910.00
2105	Нормативт зардал	20490055.00	14216711.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	379150.00	1151300.00
210502	Хоол, хүнс	20110905.00	13065411.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4729800.00	2821650.00
210604	Урсгал засвар	4729800.00	2821650.00
2107	Томилолт, зочны зардал	176000.00	188300.00
210702	Дотоод албан томилолт	176000.00	188300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1197800.00	1347900.00

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	873800.00	1347900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23943837.76	24600345.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	841700.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1213500.00	450000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21888637.76	24150345.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11173824.39	3253944.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	1825000.00	237200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1825000.00	237200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1645397.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1645397.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	645166.52	1371347.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	645166.52	1371347.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8703657.87	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8703657.87	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22411296.76	1633472.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	2713818.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	2713818.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-2713818.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22411296.76	-1080345.53

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	20,703,242.33	0.00	369,916,400.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	20,703,242.33	0.00	369,916,400.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	20,703,242.33	0.00	369,916,400.93
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	20,703,242.33	0.00	369,916,400.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	20,703,242.33	0.00	369,916,400.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,080,345.53	0.00	-1,080,345.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,382,080.00	151,831,078.60	19,622,896.80	0.00	368,836,055.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	406403500.00	397942438.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406403500.00	397942438.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	374260400.00	342905900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	374260400.00	342905900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175000.00	22625238.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	22485238.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175000.00	140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31968100.00	32411300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31968100.00	32411300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	406403500.00	372932838.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406403500.00	372932838.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395229675.61	369678893.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293262895.00	279844416.79
210101	Үндсэн цалин	193239890.00	188146639.79
210102	Нэмэгдэл	77838454.00	71426477.00
210104	Урамшуулал	22184551.00	20271300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37144097.13	36729685.85
210201	Тэтгэврийн даатгал	25191297.13	25469418.37
210202	Тэтгэмжийн даатгал	2988200.00	2830816.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2390600.00	2247853.40
210204	Ажилгүйдлийн даатгал	597600.00	561963.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5976400.00	5619633.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26320633.48	27824953.00
210301	Гэрэл, цахилгаан	2485756.48	1595130.00
210302	Түлш, халаалт	21322500.00	23377200.00
210303	Цэвэр, бохир ус	2512377.00	2852623.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5488200.00	3841238.00
210401	Бичиг хэрэг	813300.00	553600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	709800.00	757800.00
210404	Ном, хэвлэл	184500.00	184500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	455900.00	380538.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3324700.00	1964800.00
2105	Нормативт зардал	21162250.00	15585900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	875300.00	1565300.00
210502	Хоол, хүнс	19722250.00	12640600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	564700.00	1380000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6222300.00	3215000.00

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1220000.00	0.00
210604	Урсгал засвар	5002300.00	3215000.00
2107	Томилолт, зочны зардал	176000.00	188300.00
210702	Дотоод албан томилолт	176000.00	188300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1197800.00	1347900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	873800.00	1347900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4255500.00	1101500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	987200.00	237200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3268300.00	864300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11173824.39	3253944.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	1825000.00	237200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1825000.00	237200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8703657.87	1645397.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8703657.87	1645397.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	645166.52	1371347.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	645166.52	1371347.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	25009600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	25009600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	25009600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	25009600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	25009600.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-25009600.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375316000.00	375317200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375316000.00	375317200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375078800.00	372063255.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281163400.00	279844416.79
210101	Үндсэн цалин	189459100.00	188146639.79
210102	Нэмэгдэл	71430700.00	71426477.00
210104	Урамшуулал	20273600.00	20271300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37054900.00	36729685.85
210201	Тэтгэврийн даатгал	26075700.00	25469418.37
210202	Тэтгэмжийн даатгал	2744800.00	2830816.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2195800.00	2247853.40
210204	Ажилгүйдлийн даатгал	549000.00	561963.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5489600.00	5619633.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29196300.00	27824953.00
210301	Гэрэл, цахилгаан	2369100.00	1595130.00
210302	Түлш, халаалт	23377200.00	23377200.00
210303	Цэвэр, бохир ус	3450000.00	2852623.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3286000.00	3286000.00
210401	Бичиг хэрэг	413600.00	413600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757800.00	757800.00

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	184500.00	184500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225900.00	225900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1704200.00	1704200.00
2105	Нормативт зардал	15315900.00	15315900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1295300.00	1295300.00
210502	Хоол, хүнс	12640600.00	12640600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1380000.00	1380000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7224600.00	7224600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4009600.00	4009600.00
210604	Урсгал засвар	3215000.00	3215000.00
2107	Томилолт, зочны зардал	188300.00	188300.00
210702	Дотоод албан томилолт	188300.00	188300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	547900.00	547900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	547900.00	547900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1101500.00	1101500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	237200.00	237200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	864300.00	864300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	237200.00	3253944.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	237200.00	3253944.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1645397.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1371347.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	237200.00	237200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	24.00
620001	Удирдах ажилтан		1.00
620002	Гүйцэтгэх ажилтан		13.00
620003	Үйлчлэх ажилтан		10.00
620004	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22625238.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22625238.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22625238.00
2104	Хангамж, бараа материалын зардал	555238.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	154,638.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	260,600.00
2105	Нормативт зардал	270000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14000000.00
210604	Урсгал засвар	14,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22625238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22625238.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,485,238.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.07-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Зөв бодол, эерэг хандлага, сэтгэх чадвар, бүтээлч үйл, гэрэлт ирээдүйг бүтээнэ.

Зорилт: Хүүхэд нэг бүрийг эрүүл энх өсөж, бойжих хөгжих эрхийг хүндэтгэх байгаль эх орон ёс заншлаа хайрлан хүндэтгэсэн эрдэм боловсролтой "Зөв монгол" иргэн болгон төлөвшүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, бага насны хүүхдэд чанартай боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тус газар нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй болно.

Дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулан, хяналт шалгалтад хамрагдсан албан хаагч тус бүрд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 404.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.04 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.29 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд шийдвэрээр барилга байгууламж, орон сууцаас 2371.4 мянга, номын фондоос 1,396.3 мянга, машин тоног төхөөрөмжөөс 9,313.6 мянга, тавилга эд хогшлоос 783.9 мянга, бусад үндсэн хөрөнгөөс 3,000.0 мянга, программ хангамжаас 490.0 мянга төгрөгийн нийт 141 ширхэг хөрөнгө акталсан. Харин бараа материалын данснаас 5,686.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,199.7 мянга төгрөгийн бусад хангамжийн материал тус тус акталсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 7 сая төгрөгийн 20 тн чингэлэг, 14 сая төгрөгийн сантехникийн засвар тус тус хийгдэж хөрөнгөд тусгасан байна. Мөн 4,009.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшил нэмэгдэн хөрөнгөд тусгасан.

Мөн 1,957.2 мянган төгрөгийн хүүхдийн шкаф; 1,969.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер шилжин ирж, бүртгэлд тусгасан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 344.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 32.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 8.35 хувиар буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс нийт 375.3 сая төгрөгөөр санхүүжигдэн, 375.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 22.8 сая төгрөгийг бичиг хэрэг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд байгууллагын ажилчдад 1380.0 мянган төгрөгөөр хувцас, 4,009.6 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авч Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зөрчсөн, ээлжийн амралт илүү тооцон олгосон зөрчил илэрсэн. Мөн дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг олон нийтэд мэдээлсэн боловч 10 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн, ээлжийн амралтын илүү тооцон олгосон зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4. дүгээр заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитад хамрагдаагүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.046 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.389 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 0.656 сая төгрөгийн акт, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материал акталсны зардал, хөрөнгө худалдан авсны зардлыг тус тус залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Ээлжийн амралт 13 албан хаагчдад нийт 656.95 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

4.3 Албан шаардлага

Байгууллагын ажилчдад 1380.0 мянган төгрөгөөр хувцас, 4,009.6 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсан байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын хөтлөлтөд тавих хяналт сул /цагийн бүртгэл ээлжийн амралтын мэдэгдэл зөрүүтэй, нярвын тайланг нягтлан бодогч бүрэн баталгаажуулаагүй/ байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын хөтлөлтийг журмын дагуу хийх, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Шилэн дансаы холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст нийт 10 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын 1-р цэцэрлэг	6	38.939	2	32.894	1	0.656	1	5.389	2	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О. БАТЖАРГАЛ
 АУДИТЫН МЕНЕЖЕР  Д. ГАНСҮХ
 БЭЛТГЭСЭН.
 АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 02/2022/ТЭГ/МАСТА.УОС/А 1570353/08 Арвайхээр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын цалин олгохдоо 13 албан хаагчдад нийт 656.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН ОЛГОВОР ТООЦОХ ЖУРАМ”-ын 4 дүгээр зүйлд “Ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо амралт олгохын өмнөх 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг гаргах бөгөөд гарсан тоог байгууллага, нэгжид мөрдөж буй ажлын өдрийн тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг тооцож гаргана. Нэг өдрийн дундаж цалин хөлсийг ажилтны ээлжийн амралтын өдрөөр үржүүлэн ажилтанд олговол зохих ээлжийн амралтын олговрын хэмжээг тодорхойлно.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д заасан “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх амралтын мөнгийг илүү тооцон олгосон 656.9 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаас суутган Өвөрхангай аймгийн Төрийн сан дахь Өв.Орон нутгийн ерөнхий орлого 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ж.Должинсүрэн, нягтлан бодогч Ч.Сайнчулуун нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

О.БАТЖАРГАЛ
Ө.РИНЧИНМЯДАГ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар ӨДА-2022/173/НАСТА-ТОО/АИ570552/104 Арвайхээр

Арвайхээр сумын 1 дүгээр
цэцэрлэгийн эрхлэгч Ж.Должинсүрэн танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Байгууллагын ажилчдад 1380.0 мянган төгрөгөөр хувцас, 4,009.6 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсан байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ж.Должинсүрэн, нягтлан бодогч Ч.Сайнчулуун нарт даалгав.¹

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ө.РИНЧИНМЯДАГ

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.